



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 8 сарын 7 өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

Хуваарьт өөрчлөлт оруулах
тухай

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналыг харгалзан Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 123 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2014 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь”-ийг Авлигатай тэмцэх газрын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Улсын ерөнхий прокурор, Үндэсний статистикийн хорооны дарга, Үндэсний ерөнхий аудитор, Цагаатгах ажлын удирдан зохион байгуулах комиссын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Сангийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Батлан хамгаалахын сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Зам, тээврийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Хууль зүйн сайд, Хөдөлмөрийн сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайд, Уул уурхайн сайдын багцын санхүүжилтийн сар, улирлын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүгийн сар, улирлын хуваарь”-ийг 2 дугаар хавсралтаар, мөн тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2014 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Санхүүжилтийг шинэчилсэн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/-т зөвшөөрсүгэй.

САЙД



Ч.УЛААН

000394